

БАТЛАВ:
ОРХОН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР-437 ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ
АНГИЙН ДАРГА, ХУРАНДАА **М.АРИУНБОЛД**



**ОРХОН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР
437 ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИ**

Огноо: 2020-01-30

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР-437 ДУГААР
НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИЙН АЖ АХУЙН ХЭРЭГЦЭЭНД ШААРДЛАГАТАЙ БАЙГАА
ТҮЛШ ШАТАХ, ТОСЛОХ МАТЕРИАЛААР ХАНГАХ, ХУДАЛДАН АВАХ, НИЙЛҮҮЛЭХ
ОАШШГГ437/202001002 ТООТ ХАРЬЦУУЛСАН ТЕНДЕРИЙН ҮНИЙН САНАЛ АВАХ
БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: “Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар –
437 дугаар нээлттэй хорих ангийн хэрэгцээнд түлш шатах,
тослох материал нийлүүлэгч сонгон шалгаруулах”

Төслийн дугаар: ОАШШГГ437/202001002

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Түлш шатах тослох материал ханган, худалдан авах** –ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 02 дугаар сарын 10 ны өдрийн 10.00 цаг** өмнө **Орхон аймаг, Баян-Өндөр сум, Дэнж баг өөрийн байрны 1 давхар 09 тоот утас 99188665** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 02 дугаар сарын 10 ны өдрийн 10.30 цаг** -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги, Эдийн засагч, ахмад Т.Буянболд
Утас: 99188665**

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Санүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жилийн 2018 /аудитын дүгнэлт/, 2019 оны жилийн санхүүгийн тайлан, e-balance цахим бүртгэлд шивэгдсэн байх</p> <p>Сүүлийн 2 /хоёр/ туршлагын мэдээлэл: Гэрээгээр нийлүүлсэн барааны ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн актын хуулбар ирүүлэнэ. Мөн санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/</p> <p>Бусад нэмэлт шаардлага: Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн тухай эрх бүхий байгууллагын мэдэгдэл /татварын өртэй тохиолдолд тендерт оролцогчийг эрх бүхий бус гэж үзнэ./ ✓ Тендерт оролцогч эрх бүхий болохоо илэрхийлсэн мэдэгдэл. ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ✓ Үйлдвэрлэл, борлуулалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэх ✓ Төлөөлөх этгээдийн итгэмжлэл ✓ Шатахуун /АИ-95, АИ-92, А-80, Дизель түлш/ -ын гарал үүслийн бичгийн хуулбар ✓ Стандарт хэмжилзүйн газарт барааны чанар байдлын дүгнэлт /сүүлийн 3 сарын дотор хийгдсэн байх/ ✓ Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай шатахуун түгээх станцыг байршлын жагсаалт ✓ Барааны үнийн хуваарийг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. ✓ Шүүхийн байгууллагын тодорхойлолт. ✓ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт ✓ Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, бөөнөөр болон

	жиглэнгээр худалдаалах тусгай зөвшөөрөлтэй байх.
ТӨЭЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Дэнж баг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 9 тоот Огноо: 2020-02-10 өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТӨЭЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Дэнж баг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 9 тоот Огноо: 2020-02-10 өдөр Цаг: 10 цаг 30 минут
ТӨЭЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: / Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих ангид шаардлагатай байгаа шатахуунаар хангах, худалдан авах ОАШШГГ437/202001002 тоот харьцуулсан тендер/ Багцгүй

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Д/д	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлтийн хэмжээ	Шинжилгээний арга
1	Шинжилгээний аргаар	92	ГОСТ 32339, ГОСТ 511
2	Моторын аргаар	83	ГОСТ 32340, ГОСТ 8226
3	Хар тугалганы агууламж, мг/дм ³ , ихгүй	5	MNS5845, EN 237 ГОСТ 32350, ГОСТ 28828
4	Бензины индукцийн үе /исэлдэлтийн тогтвор/, мин, багагүй	360	ГОСТ4039
5	Хүхрийн агууламж, ихгүй мг/кг	500 150 50 10	MNS 470 ГОСТ 32139 ISO 20846 ISO 20448
6	Бензолын агууламж экологийн ангилалд, эзлэхүүний хувь, ихгүй K3, K4, K5	5 1	MNS ASTM D6277 MNS GOST 29040 EN 12177 ГОСТ 32507
7	Нүүрс ус төрөгчдийн эзлэхүүний хувь, экологийн K3, K4, K5 ангилалд % ихгүй -олефиний -ароматик	18,0 35,0 /42,0-K3 экологийн ангилалд/	MNS GOST 29040 ГОСТ 32507 ГОСТ 31872
8	Хүчилтөрөгчийн жингийн хувь, K3, K4, K5 экологийн ангилалд % ихгүй	2.7	EN 13132 EN 1601
9	Хүчилтөрөгчит нэгдлийн эзлэхүүний хувь, %, ихгүй -метанол -этанол -изопропилын спирт -гуравдагч путилын спирт -изопутилын спирт -эфирүүд /C5 ба дээд/ -бусад хүчилтөрөгчит нэгдэл /210 градусаас ихгүй температурт буцалдаг/	1,0 5,0 10,0 7,0 10,0 15,0 10,0	ГОСТ EN 12132 ГОСТ 32338 ГОСТ EN 1601
10	Зэс хавтгайн туршилт /50 градуст 3 цаг/	Ангилал 1	MNS ISO 2160 ГОСТ 6321 ГОСТ 32329
11	Өнгө, гадна төрх	Цэвэр, тунгалаг	Нүдээр ажиглах
12	Нягт, 15 градуст, кг/м ³	725,0-780,0	MNS GOST RR 51069 MNS ASTM D4052 ГОСТ 31072 ГОСТ 31392

13	Марганцийн агууламж мг/дм ³ , ихгүй	байхгүй	ГОСТ P51926
14	Төмрийн агууламж, мг/дм ³ ихгүй	байхгүй	ГОСТ32514
15	Монометиланилин эзлэхүүний хувь, %, экологийн ангилалд, ихгүй: K2 K3, K4 K5	1,3 1,0 байхгүй	ГОСТ 32515
<p>1-Р ТАЙЛБАР: 7-оос 9 дэх үзүүлэлтийг K2 экологийн ангилалын бензинд тодорхойлохгүй байж болно.</p> <p>2-Р ТАЙЛБАР: Бүтээгдэхүүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хар тугалганы агууламж 2,5 мг/дм³-аас бага - Төмрийн агууламж 0,01 г/дм³-аас бага - Марганец 0,25 мг/дм³-аас бага - Метанол эзлэхүүний 0,17%-иас бага бол тэдгээрийг байхгүй гэж үзнэ. <p>3-Р ТАЙЛБАР: Литрийн нэгжийн эмхэтгэсэн болон хувилсан нэгжийг “Хэмжлийн хуульчилсан нэгж, MNS OIML D 2:2014” стандартын “4,3 Эзлэхүүн”-т заасны дагуу ойлгоно. Жишээ нь: 1л=1дм³=10³ м³</p>			

Этилжүүлээгүй бензиний уурших чанарын ангилал

№	Үзүүлэлтийн нэр	Ангилсан үзүүлэлт тус бүрийн хэмжээ						Шинжилгээний арга
		A	B	C ба C1	D ба D1	E ба E1	F ба F1	
0	1	2	3	4	5	6	7	8
1	Хансан уурын даралт /ХУД/, кПа: Зуны улиралд: Өвөл ба завсрын улиралд:	35-80 35-100						MNS 3626 MNS GOST 28781 EN 13016-1
2	Найрлагын бүрэлдэхүүн: ууршилт, эзлэхүүний хувь, % температурын үед: 70 ⁰ C /И70/ 100 ⁰ C/И100/ 150 ⁰ C/И150/, Багагүй буцалж дуусах, C, ихгүй колбо дахь үлдэгдэл эзлэхүүний хувь, %, ихгүй	15-48		15-50 40-70 75-215,0 2,0				MNS ISO 3405 MNS GOST 22055
3	Ууршилтын индекс, хамгийн дээд хэмжээ, УИ	-	-	C1, D1, E1, F1-д 1350				Энэ стандартын 9.3-аар тодорхойлно.
➤ Бензиний ангилал: Зуны- A, B Өвлийн –C, D, E, F; Завсрын улиралд-C1, D1, E1, F1								

Дизелийн түлш ерөнхий шаардлага

№	Үзүүлэлтүүд	Зөвшөөрөгдсөн хэмжээ		Шинжилгээний арга
		Зун	Өвөл	
1	Цетаны тоо, багагүй	47-89		MNS GOST 27768
2	Хувийн жин, 15 ⁰ С-тг/ см ³ ихгүй	820-845		MNS 481:1988
3	Найрлагын бүрэлдэхүүн: 180 ⁰ С нэрэгдэх эзэлхүүний %, багагүй		10	MNS ISO 3405:2000
	250 ⁰ С нэрэгдэх эзэлхүүний %, багагүй	65		
	350 ⁰ С нэрэгдэх эзэлхүүний %, багагүй	85	85	
	95% нэрэгдэх температур ⁰ С, ихгүй	360	360	
4	Нийт хүүхрийн хэмжээ хувь, ихгүй	K3/350, K4/50, K5/10		MNS 337:1983
5	Шүүгдэх чанарын дээд температур, ⁰ С дээшгүй	5-/-10/	Хасах 20 Хасах 38	MNS 3192:1996
6	Булингартан температур, ⁰ С дээшгүй		Хасах 10 Хасах 28	MNS 3594:1983
7	Битүү тагшинд дүрсхийн асах температур ⁰ С доошгүй	55	30-55	MNS 333:1983
8	Усны агууламж, мг/кг, ихгүй	200		MNS 332:1996
9	Зэс хавтгайн туршилт /50 ⁰ С- т 3 цаг/	тэсвэртэй		MNS ISO 2160
10	Усанд уусдаг хүчил шүлтийн хэмжээ %	байхгүй		MNS 324:1983
11	Үнсжилт, эзэлхүүний %, ихгүй	0.01		MNS 3501:1983
12	Механик хольцийн хэмжээ, %	Байхгүй		MNS 3697:1984
13	40 ⁰ С дахь кинематик зууралдлага, мм ² /с /сСт/	2.0-4.5	1.5-4.0	MNS 480:1983
14	Өнгө	Тодорхойлно.		MNS (ISO) 2049-2000

Тайлбар: Захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлага: ГОСТ 305-2013/MNS 216:2017 стандартад нийцсэн байх ёстой

2. **Стандарт:** [Тухайн барааны гарал үүсэл Монгол Улсын зохих стандартад нийцсэн байна.]
3. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**[Тухай бүр хуваарийн дагуу бараа нийлүүлэлтийг хийнэ.]

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
<i>Хэрэгцээтэй үед бэлэн байлгах</i>							
Аи-92		7500	л	Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги	бэлэн	бэлэн	
А-80		1000	л	Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги	бэлэн	бэлэн	
Аи-95		1700	л	Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги	бэлэн	бэлэн	
Дизель түлш		6500	л	Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги	бэлэн	бэлэн	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-437 дугаар нээлттэй хорих анги)-ын дарга **М.Ариунболд** танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхой лолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [2] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д 30] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- Барааны үнийг сар бүрийн эцэст хийх- Хагас бүтэн жилээр барааны үнийн тооцоог дуусгаж тооцоо нийлсэн акт үйлдэх |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: 0</p> <p>Алдангийн нийт дүн: 0</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]